*Тайланг хянасан:* ***ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ***

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД ................................... Т.МӨНХСАЙХАН
(албан тушаал) (гарын үсэг)
...................................
(огноо)

*Тайланг б:* ***ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ***

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ ................................... Ц.УРАНЧИМЭГ
(албан тушаал) (гарын үсэг)
2024.12.13
(огноо)

## АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| *д/д* | *Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж* | *Төсөв (сая төгрөг)* | *Шалгуур үзүүлэлт* | *Хугацаа* | *Зорилтот түвшин* | *Гүйцэтгэл* | *Хувь* |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 1. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ** | | | | | | | |
| ***Зорилт 1.1 Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх*** | | | | | | | |
| 1 | МУУХХБ – 2.2.13<br>МУТЖҮЧ - 2.2.3<br>СТ-5.1.1.10<br>Арьсны хавдрын үед хийгдэх МОН-ын мэс заслыг шинээр нэвтрүүлнэ. | 2.0 | Мэс засалд хамрагдсан үйлчлүүлэгийн тоо | I-IV улирал | Арьсны хавдрын МОН-ын мэс заслыг нэвтрүүлсэн байна. Мэс засалд хамрагдсан | МОН'S мэс заслыг нэвтрүүлэх ажлын хүрээнд арьсны мэс заслын эмч Д.Сүхболдийг 2021 онд, Т.Булганцэцэг эмчийг 2024 онд сургаж бэлтгэсэн. Арьсны эмгэг судлаач эмч Э.Дэлгэрзаяаг ЭМЯ-ы санхүүжилтээр нэн шаардлагатай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | МУУХХБ – 2.2.13<br>МУТЖҮЧ - 2.2.3<br>СТ-5.1.1.10<br>Арьсны хавдрын үед хийгдэх МОН-ын мэс заслыг шинээр нэвтрүүлнэ. | 2.0 | Мэс засалд хамрагдсан үйлчлүүлэгийн тоо | I-IV улирал | Арьсны хавдрын МОН-ын мэс заслыг нэвтрүүлсэн байна. Мэс засалд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо 1-2 байна. | MOH'S мэс заслыг нэвтрүүлэх ажлын хүрээнд арьсны мэс заслын эмч Д.Сүхболдийг 2021 онд, Т.Булганцэцэг эмчийг 2024 онд сургаж бэлтгэсэн. Арьсны эмгэг судлаач эмч Э.Дэлгэрзаяаг ЭМЯ-ы санхүүжилтээр нэн шаардлагатай мэргэжлээр Тайван улсад 2024 оны 10 сард 3 сарын сургалтад мэргэжил дээшлүүлэх сургалтад илгээгээд байна.<br>DS: Basal cell carcinoma оноштой 71 настай эрэгтэйд МОН хагалгааг амжилттай хийсэн.<br> <br>Мөн АНУ-ын Dana-Farber Cancer Institute, Brigham Cancer Center-ээс гаргасан “MOHS surgery and reconstruction” өвчтөнд зориулсан гарын авлагыг орчуулан бэлтгэж байна. | 100 |
| 2 | МУУХХБ – 2.2.13<br>МУТЖҮЧ - 2.2.3<br>СТ-5.1.1.2<br>Арьсны өвчнүүдийн үед хийгдэх бай эмчилгээг өргөжүүлнэ. | 6.0 | Бай эмчилгээний төрөл | I-IV улирал | Omalizumab эмчилгээг шинээр нэвтрүүлсэн байна. Нэвтрүүлсэн бай эмчилгээний | Харшлын иммуноглобулин E хамааралт урвалын үед IgE-н ялгаралтыг хориглогч Omalizumab бай эмчилгээг кортикостеройдын хэрэглээг бууруулах, алсын гаж нөлөөнөөс сэргийлэх зорилгоор шинээр нэвтрүүлсэн. Одоогоор 6 жил хөхний экзема болон архаг дахилтат | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрөл 2 болсон байна. | чонон хөрвөсөөр өвдөж буй Э.Г 34 настай эмэгтэйд 2024 оны 8-р сараас эхлэн сард 1 удаа тарилгын хэлбэрээр хийж байна. Эмчилгээний үр дүнг тооцох хугацаа хараахан болоогүй байна.<br>Энэхүү эмчилгээ нь эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй, 1 удаагийн тун нь 1.4 сая төгрөгийн үнэтэй бөгөөд IgE түвшин хэвийн болсоноос хойш 3 сар хэрэглээд зогсоодог тул 1 жилд 16,8 сая төгрөг зарцуулах шаардлагатай тул тусламж үйлчилгээг нэвтрүүлэхэд бэрхшээл туларч байна.<br>Омализумаб нь АӨСҮТөвийн тусламж үйлчилгээндээ нэвтрүүлж буй 3 дахь бай эмчилгээ болно. | |
| 3 | МУТЖҮЧ 2.2.3<br>СТ-5.1.1.7<br>Гэрлийн хавьтлын сорилыг нарны харшил, гэрлийн дерматитийн оношилгоонд нэвтрүүлнэ. | 10.0 | Оношилгоо хийлгэсэн үйлчлүүлэгчийн тоо | I-IV улирал | Гэрлийн хавьтлын сорил нийт 10 үйлчлүүлэгчид хийгдсэн байна. | Гэрлийн хавьтлын сорилыг нарийн зурваст хэт ягаан туяа эсвэл 311 нм долгионы урттай экзаймер лазераар хамгийн бага улайрлын тун ашиглан нарны харшил, гэрлийн дерматитийн оношилгоог сайжруулж байна. 2024 онд эксимер лазер эмчилгээнд нийтдээ эхний 11 сарын байдлаар 89 хүн, walldmann-д нийт 1146 үйлчлүүлэгчид хамгийн бага улайрлын тунг тодорхойлсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |   | |
| 4 | МУУХХБ – 2.2.13<br>МУТЖҮЧ 2.2.3<br>СТ-5.1.1.6<br>Үс шилжүүлэн суулгах мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлнэ. | 20.0 | Үс шилжүүлэн суулгасан үйлчлүүлэгчийн тоо | I-IV улирал | Нийт 3 үйлчлүүлэгчид үс шилжүүлэн суулгасан байна. | Үс шилжүүлэн суулгах эмч, сувилагч нарыг бэлтгэж, хагалгааны тоног төхөөрөмжийг энэ оны 04 дүгээр сард хүлээж авч, 3 үйлчлүүлэгчдэд мэс заслыг амжилттай хийсэн.<br>Ч.Б нас 38 эрэгтэй DS: Androgenic Alopecia 3500 ширхэг үс шилжүүлэн суулгасан.<br> <br>Үс шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгчдийн үр дүнг дараах байдалтай байна: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>Өмнө Дараа<br><br>Өмнө Дараа | |
| 5 | МУУХХБ – 2.2.12<br>СТ-2.1.3.14<br>Арьс, харшлын өвчний оношилгоо эмчилгээний нийт 6 эмнэлзүйн заавар боловсруулж батлуулна. | 1.0 | Батлагдсан оношилгоо эмчилгээний эмнэлзүйн зааврын тоо | I-IV улирал | Арьс, харшлын өвчний оношилгоо эмчилгээний нийт 6 эмнэлзүйн заавар шинээр боловсруулж батлуулсан байна. | Эмнэлзүйн олон улсын шалгуурын дагуу арьс, харшлын өвчний оношилгоо, эмчилгээний 6 эмнэлзүйн зааврын төслийг боловсруулж ЭМЯ-нд хүргүүлээд байна.<br>1) Цэлцрүүт пемфигойд өвчний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар<br>2) Ягаан үлд өвчний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар<br>3) Хавьтал харшлын дерматит өвчний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар<br>4) Чонон хөрвөс өвчний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5) Арьсан дотор тарих сорилын өвчний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар<br>6) Бүслүүр үлд өвчний оношилгоо эмчилгээний эмнэлзүйн заавар | |
| 6 | ЗГҮАЧ - 2.1.10<br>СТ – 2.1.3.5<br>Байгууллагын үйлчилгээний стандартыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | 10.0 | Гаргасан өргөдөл, гомдлын тоо | I-IV улирал | Байгууллагын үйлчилгээний стандартыг бүрэн хэрэгжүүлж, гомдол саналгүй ажилласан байна. | Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага MNS 7014:2023 стандартыг байгууллагын хэмжээнд мөрдөж ажилладаг.<br>➢ Эмч, эмнэлгийн мэрэгжилтнүүд ёс зүйн хэм хэмжээг баримталж, үйлчлүүлэгчдийг ялгаварлахгүй, тэгш байдлыг хангаан мэдээллийг өгч үйлчилдэг<br>➢ Сонсголийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах зорилгоор байгууллагын хөтөч болон цахим бүртгэлийн ажилчдад дохионы хэлийг сургаж эрүүл мэндийн чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны материалыг брайль үсгээр хэвлүүлэн цахим бүртгэлийн хэсэгт байршуулсан.<br>➢ Эмч, эмэнлэгийн ажилтан бүр байгууллагын дотоод журмын дагуу ажлын байранд жигд хувцаслаж, энгэрийн таних тэмдэг зүүж, гадаад байдлын хэм хэмжээг дагаж мөрдөж хэвшсэн<br>➢ Төвийн өрөө, тасгийн байршил чиглэлийг заасан үйлчилгээний чиглэлийн тэмдэг, тэмдэглэгээ, үйлчлүүлэгчид хэрэгцээт мэдээлэл бүхий дуугүй хөтчийг ойлгомжтойгоор хийж байршуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчилгээ авах орчин нөхцлийг бүрдүүлж, налуу шат, ханын бариул, тэргэнцэр, ариун цэврийн өрөөг тохижуулсан.<br>➢ Амбулаторийн үзлэг, шинжилгээний дугаар авах, цаг товлох үйл ажиллагааг цахим технологи, утас, киоск машин ашиглан шийдвэрлэдэг<br>➢ Байгууллагын орох хаалганы хэсэгт унах эрсдэлтэй, хэвтрийн үйлчлүүлчид зориулсан тэргэнцэр, таяг байршуулсан.<br>➢ Лавлагаа мэдээллийн цэгт байгууллага, тасаг, нэгжийн үйл ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, үйлчилгээний багц, төлбөрийн мэдээллийг ил тод байршуулсан.<br>➢ Иргэний өргөдөл, гомдлыг аман, биечлэн, утсаар, цахимаар, 11-11, бичгээр, санал хүсэлтийн дэвтэрээр хүлээн авч бүртгэн, хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажилладаг. Улирал бүр иргэний өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн тайланг ЭМХТ хүргүүлдэг. 2024 оны 11 сарын байдлаар нийт 52 буюу санал, хүсэлт - 1, өргөдөл, гомдол – 49 , талархал - 1 хүлээн авч, өргөдөл, гомдлыг 100% шийдвэрлэж ажилласан. | |
| ***Зорилт 1.2 Арьс харшлын өвчний тусламж, үйлчилгээг чанартай үзүүлэх, нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх*** | | | | | | | |
| 7 | МУУХХБ-2.2.11, ЗГҮАЧ-2.1. | 50.0 | | I-IV | | Тусламж, үйлчилгээнд цаг товлох үйлчилгээг нэвтрүүлж төвийн утсаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | СТ-2.1.1.3 Үйлчлүүлэгч утсаар, цахимаар цаг товлох, зөвлөгөө мэдээлэл авах үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана. | | Утсаар цаг товлох үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн хувь | улирал | Утсаар цаг товлох үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоог нэмэгдүүлсэн байна. | цаг товлох үйлчилгээ авах журмыг баталж мөрдөн ажиллаж байна.<br>2024 оны байдлаар утсаар болон цахимаар цаг товлох үйлчилгээг 13317 үйлчлүүлэгчид үзүүлсэн.<br>Цаг товлосон иргэдтэй утсаар урьдчилан холбогдож баталгаажуулснаар 2100 орчим үйлчлүүлэгчийн цаг товлолыг цуцалж, дараагийн хүлээгдэж буй үйлчлүүлэгчид шилжүүлж хүлээгдэл чирэгдлийг бууруулах тал дээр анхаарч ажиллаж байна. | 100 |
| 8 | МУТЖҮЧ-2.2.3,<br>ЗГҮАЧ-2.1.<br>СТ-2.1.1.4<br>Амбулаторийн эмчийн үзлэгийн кабинетын тоо, нэр төрлийг нэмэгдүүлнэ. | 35.0 | Шинээр байгуулсан кабинетын тоо | I-IV улирал | Шинээр мэс заслын кабинеттай болсон байна. Амбулаторийн эмчийн үзлэгийн кабинетын тоо 15 болсон байна. | Амбулаторид шинээр мэс заслын 1, харшлын 1 кабинет шинээр нээгдэж нийт 17 кабинет ажиллаж байна. Үүнд:<br>➢ Арьсны кабинет 10<br>➢ Харшлын кабинет 5<br>➢ Мэс заслын кабинет 1<br>➢ Дүрс оношлогоо кабинет 1<br>2024 оны 11 сарын байдлаар амбулаторийн арьс харшлын кабинетаар нийт 73840, ЭГЗНСТ-аар нийт 12149, мэс заслын тусламж үйлчилгээг нийт 246 үйлчлүүлэгчид үзүүлсэн. Нийт үзлэг өмнөх онтой харьцуулахад 2022 онд 43,9%-р, 2023 онд 1,9 хувиар тус тус өссөн байна. Үүнээс амбулаторийн үзлэг өмнөх онтой харьцуулахад 2022 онд 44,9%-р өссөн бол 2023 онд өмнөх оноос 2,1%-р буурсан байна.<br>ЭГЗНС-н үзлэг өмнөх онтой харьцуулахад 2022 онд 38,7%-р, 2023 онд 25,7 хувиар тус тус өссөн байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дүрс оношлогооны кабинетээр нийт 282 үйлчлүүлэгч шинжилгээнд хамрагдсан. Үүнд:<br>- Арьсны хэт авиа - 26<br>- Хэвлийн хэт авиа - 282<br>- Бамбай булчирхайн хэт авиа/ - 12<br>Илэрсэн өөрчлөлтийн зарим статистик үзүүлэлтээр:<br>1. Элэгний хавдар 5<br>2. Цөсний хүүдийн чулуу 51<br>3. Бөөрний чулуу 5<br>4. Целлюлит 13<br>5. Липома 8<br>6. Меланома 3<br>7. Арьсны бүтцийн өөрчлөлт 3 байна. | |
| 9 | МУТЖҮЧ-2.2.11<br>СТ-2.1.1.6<br>Өдрийн эмчилгээний үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 150.0 | Өдрийн эмчилгээнд хамрагдсан эмчлүүлэгчийн тоо | I-IV улирал | Өдрийн эмчилгээнд хамрагдсан эмчлүүлэгчийн тоо 350,<br>Озон эмчилгээнд хамрагдсан эмчлүүлэгчийн тоо 200 болсон байна. | Өдрийн эмчилгээнд нийт 450 үйлчлүүлэгч хамрагдсан. Арьс хатгах сорил 4502, плазмаферез 619, цус шүүх эмчилгээ 149 үйлчлэгчид тусламж үйлчилгээг үзүүлсэн.<br>Зонхилон тохиолдох өвчнөөр атопийн дерматит, хайрст үлд, архаг экзем, чонон хөрвөс, мөөгөнцөр оношоор эмчилгээнд хамрагдаж байна.<br>Дараах оношийн хамааралтай бүлгүүдийг өдрийн эмчилгээгээнд хамруулж байна. Үүнд:<br>- Түүхий<br>- Арьсны буглаа, хатиг ба мундас<br>- Батга, ягаан батга<br>- Бүслүүр үлд<br>- Арьсны үлд, кандидоз<br>- Хамуу<br>- Арьсны цэврүүтэх өвчин<br>- Атопит дерматит<br>- Хайрст дерматит | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хавьтлын харшилт дерматит<br>- Энгийн хавьтлын цочролт дерматит<br>- Загатнаа, бусад дерматит<br>- Гүвдрүү хайрст эмгэг/псориаз/<br>- Чонон хөрвөс ба эритем<br>- Арьс цайх өвчин<br>- Голомтот халцрал<br>- Сорвижилгүй бусад үс уналт, Сорвижилт халзрал<br>- Арьс ба арьсан доорх эслэгийн фолликулт үйланхай<br>- Нөсөөжих эмгэг<br>- Хайрст кератоз<br>- Арьс харлан зузаарах<br>- Эвэр ба эвэрших<br>Тус оны 11 сарын байдаар озон эмчилгээний тусламж үйлчилгээнд нийт 75 үйлчлүүлэгч хамрагдаад байна.<br>Озон эмчилгээг арьсны өвчтэй дараах үйлчлүүлэгдэд хийж байна. Үүнд:<br>- Арьсны идээт өвчнүүд<br>- Вирусын гаралтай өвчнүүд<br>- Мөөгөнцрийн гаралтай өвнүүд<br>- Хайрст үлд, нейродерматит<br>- Дерматитүүд<br>- Экзема<br>Озон эмчилгээний үр дүн дунджаар 85 хувьтай байна. | |
| 10 | МУТЖҮЧ 2.2.3<br>СТ-2.1.1.5<br>Эмчилгээний гоо заслын эмчилгээний нэр төрөл,тоо хэмжээг нэмэгдүүлнэ. | 30.0 | Гоо заслын эмчилгээнд нэвтрүүлсэн нэр төрлийн тоо | I-IV улирал | Шинээр 3 эмчилгээний нэр төрөл нэмэгдсэн байна. | Эмчилгээний гоо засалд дараах эмчилгээний технологийг шинээр нэвтрүүлсэн:<br>➢ Үс шилжүүлэн суулгах заслын тусламж үйлчилгээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br><br><br>➢ Арьсны хавдрын үед хийгдэх МОН-ын мэс заслын тусламж үйлчилгээ<br>➢ Арьсан доорх өөхөн эдийн хоргүй хавдар авах мэс засал<br><br><br>➢ Арьсан доорх өөхөн эдийг задлах, коллагены нийлэгжилтийг нэмэгдүүлэх утас суулгах мэс ажилбар<br> | |
| 11 | МУЗГҮАХ 2.1.7<br>МУТЖҮЧ 2.2.7<br>СТ-6.1.1.4<br>2 талт эмийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ. | 350.0 | Борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл, орлогын хэмжээ | I-IV улирал | Борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдсэн байна. | Амбулаторит 2 талт эмийн сангийн үйлчлүүлэгчид хүргэж буй эмийн нэр төрлийг олшруулж арьс арчилгааны 43 нэр төрлийн бүтээгдэхүүнээр хангаж ажилласан. Эхний хагас жилээр 19.931.140 төгрөгийн борлуулалттай ажилласан. | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>2024 оны 06 дугаар сараас байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар тус эмийн сангийн үр ашгийг тооцож дүгнэн ТУЗ-ын тогтоолоор 2 талт эмийн санг татан буулгасан. | |
| 12 | МУЗГҮАХ - 2.1.7<br>МУТЖҮЧ - 2.2.7<br>СТ – 6.1.2.7<br>Чанарын шаардлага хангасан дотоодын эм бэлдмэлээр бүрэн хангана. | 60.0 | Борлуулсан бүтээгдэхүүний нэр төрөл | I-IV улирал | Эмчилгээнд хэрэглэх дотоодын найруулсан эм, бэлдмэлээр бүрэн хангагдсан байна. | Эмчилгээний тусламж үйлчилгээнд дотоодын найруулсан эм, бэлдмэлээр тасаг нэгжийг бүрэн хanган ажилладаг. Дотооддоо 20 гаруй нэр төрлийн тос тосон түрхлэг, усан уусмалыг бэлдмэлийг найруулан бэлтгэдэг. Үүнд:<br>• Цайрын исэлтэй тос 5%, 10%, 15%,20%,<br>• Салицилын хүчилтэй тос 2%, 5%,<br>• Стрептоцидтэй тос 5%, 10%<br>• Унна тосон бэлдмэл<br>• Хүхэр 2%, 3%, 5%, 10%,15%<br>• Бура маск<br>• Фурациллины уусмал<br>• Перкись уусмал 2%, 3%<br>• Кастеллян уусмал зэрэг<br>11 сарын байдлаар 902кг 196гр тосон түрхлэг, 470л 800 мл усан уусмалыг эм найруулах технологийн дагуу найруулан бэлтгэж тасаг нэгжийг бүрэн хanган ажилласан. | 100 |
| **ЗОРИЛГО 2. ИРГЭДЭД НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ** | | | | | | | |
| ***Зорилт 2.1 Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох*** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | МУТЖҮЧ - 2.2.2<br>ЗГҮАХ - 2.1.1.6.<br>СТ - 1.1.1.2<br>Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | 100.0 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | I-IV улирал | 3 зорилтын хүрээнд нийт 9 ажлыг бүрэн хэрэгжүүлсэн байна. | ЭМС-ын 2021 оны А/816 тоот тушаалаар батлагдсан харшлаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх 3 зорилтын хүрээнд 2024 онд 9 ажил төлөвлөж, АӨСҮТ-ийн гүйцэтгэх захирлын А/32 тоот тушаалаар 11 аймгийн 26 төлөөллийн бүрэлдэхүүнтэй хамтарсан ажлын хэсгийг баталж дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>1. Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах замаар харшлын шалтгаант өвчлөл, түүний хүндрэлийг бууруулах зорилгын хүрээнд:<br>➢ Ургамлын тоосны харшлын эмнэлзүйн онцлог, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт сэдэвт сургалтыг харшлын их эмч, АУ-ны доктор С.Байгалмаа АӨСҮТ-ийн ургамал судлаач, биологийн магистр П.Минжбадрах нар удирдан 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд 14 аймгийн 300 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан.<br>  | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢Боловсролын ерөнхий газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн боловсролын газартай хамтран 2024 оны 09 сарын 17, 18-ны өдөр Аймаг, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй эрүүл мэндийн багш, эмч нарт “Харшлын өвчнөөс сэргийлэх, эрсдэлийг бууруулах" сэдэвт чадавхжуулах цахим сургалт зохион байгуулсан.<br>➢Суурьшлын бүсийн сул шороон хөрсийг харшил үүсгэдэггүй зөвшөөрөгдсөн 12 зүйлийн ургамлаар зүлэгжүүлж, харшлын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах мэдээлэл бүхий 35 хуудас зөвлөмж, гарын авлагыг төслийн хугацаанд хэвлүүлж, аймаг орон нутгийн ажлын хэсэгт тараасан<br>➢Шарилжгүй хот, шарилжгүй аймаг” харшлын эсрэг хамтдаа аяны хүрээнд албан байгууллага, айл өрх, иргэдэд зориулсан харшлаас сэргийлэх, хөл газрын ургамал хадаж, тайрах аргачлал болон зөвлөмж, инфографик мэдээллийг аймаг, сумдын цахим сүлжээгээр түгээсэн. Албан байгууллага, орон нутгийн иргэд харшил төрүүлэгч хөл газрын ургамлыг хатааж, тайралт хийн нийт 16534.5 га талбайг цэвэрлэж харшлаас сэргийлэх аянд идэвхтэй оролцсон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Арьс, харшлын өвчний оношилгоо эмчилгээний 6 эмнэлзүйн зааврын төсөл боловсруулан АӨСҮТ-ийн дэргэдэх арьс судлалын салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн ЭМЯ-нд хүргүүлсэн<br>2. Харшлын эрсдэлт хүчин зүйлсийг бууруулж, хүн амын мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд ургамлын гаралтай харшлаас сэргийлэх 7 зөвлөмж, телевизийн ярилцлага 5 удаа, 4 инфографик боловсруулж иргэдэд мэдээлэл хүргэсэн.<br>Дараар сэдвээр телевизэд ярилцлага өгсөн:<br>- Шарилжаас үүдэлтэй харшил хүүхдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар /ТВ-5/<br>- Тоосонцрын хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө /ETV, MNB/<br>- Дотоод орчны харшил үүсгэгч хүчин зүйлс /Тэнгэр ТВ/<br>- Багтраа өвчин ба харшил /MNB/<br>- Агаарын бохирдол ба харшил хүүхдийн эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх талаар /Тэнгэр, Монгол HD телевиз/<br>Дараах сэдвээр зөвлөмж, шарын авлага бэлтгэж хүргэсэн:<br>- Хүнсний харшил<br>- Харшил үүсгэгч гадаад орчны хүчин зүйлс<br>- Иргэд өөрийгөө юунд харшилтай эсэхээ тодорхойлох талаар<br>- Ургамлын тоосны харшлаас хэрхэн урьдчилан сэргийлэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хүнсний харшлаас урьдчилан сэргийлье видео зөвлөмж<br>- Ургамлын тоосны харшил<br><br>Хөрсний бохирдол ба эрүүл мэндэд үзүүлэх нөлөө сэдвээр НЭМҮТ-тэй хамтран 4 төрлийн инфографик боловсруулсан | |
| 14 | МУУХХБ – 2.2<br>МУТЖҮЧ-2.2.2<br>СТ 1.1.1.4<br>Үйлчлүүлэгчдэд арьс, харшлын чиглэлээр эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажил хийнэ. | 3.0 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br>Хандалтын тоо | I-IV улирал | Нийт 80000 иргэдэд эрүүл мэндийн зөвлөгөөг өгч, 30 гаруй төрлийн мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас болон пэйж хуудаст нийтэлж, олон нийтийн хандалтыг нэмэгдүүлсэн байна. | Хүн амын дунд эрүүл мэндийг дэмжих, арьс, харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр нийт 17 ярилцлага, 4 контент бэлтгэн, 1500 орчим гарын авлага, тарааж ажилласан.<br>Дараах сэдвээр подкаст, ярилцлага хэлбэрээр мэдээлэл хүргэсэн. Үүнд:<br>1) Лабораторийн тасгийн ахлах лаборант Ч.Буманзаяа "Шинжилгээ өгөхөд анхаарах зүйлс"<br>2) Клиникийн II-р тасгийн эрхлэгч Ж.Аззаятай "Электрон тамхи буюу (vape) эрүүл мэндэд нөлөөлөх"<br> | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3) Поликлиникийн тасгийн сувилагч Н.Оюунзул "Харшлын сорил өгөхөд анхаарах зүйлс”<br>4) Хүүхдийн тасгийн их эмч Т.Бадамгарав "Атопийн дерматит”<br>5) ЭГЗНСТ-ийн эрхлэгч Г.Баянжаргал “Батга” өвчний талаар<br><br><br>6) ЭЭЯТТасгийн сувилагч Х.Одсүрэн "Эмийн гаж нөлөө”<br>7) Харшил судлалын лабораторийн ургамал зүйч, биологийн ухааны магистр П.Минжбадрах "Улиасны унгирал”, "Ургамлын тоосны харшил”<br><br><br>8) Харшил, дотрын их эмч, АУ-ны доктор С.Байгалмаа “Ургамлын тоосны харшил өвчний шалтгаан тархалт, оношилгоо эмчилгээ”<br><br>9) Поликлиникийн тасгийн их эмч М.Жамбалсүрэн "Хайрст үлд”<br>10) Арьс харшлын их эмч У.Саруул “Эмийн харшил” | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | <br>11) ЭГЗНСТ-ийн их эмч И.Мөнхзаяа "Арьс цайх өвчин"<br>12) Клиникийн II тасгийн их эмч Б.Дашдулам "Ягаан батга"<br>13) Клиникийн I тасгийн их эмч Э.Баасанхүү "Бүслүүр үлд"<br>14) СЭША-ны дарга, дүрс оношлогооны эмч Б.Лхагвасүрэн "Арьсны хэт авиан шинжилгээ"<br>15) Хүүхдийн тасгийн их эмч Н.Золбаяр "Бөөсжилт"<br><br><br>16) Хүүхдийн тасгийн эрхлэгч Д.Уранцэцэг "Бөөсжилт" сэдвээр тус тус мэдээлэл хүргэсэн. | |
| **ЗОРИЛГО 3.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАЖ ЭРСДЭЛЭЭС СЭРГИЙЛЭХ** | | | | | | | |
| ***Зорилт 3.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоо, арга хэрэгслийг сайжруулан, тасралтгүй байдлыг хангах*** | | | | | | | |
| 15 | МУТЖҮЧ-2.2.7<br>ЗГҮАХ–2.1.8<br>СТ-2.1.3.1<br>Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлээр орох | 30.0 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | I-IV улирал | Магадлан итгэмжлэлээр орох бэлтгэл ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 90-эс дээш хувь болсон байна. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам батлах тухай" А/503 дугаар тушаалын дагуу магадлан итгэмжлэлийн шалгалтанд бэлтгэл ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг АӨСҮТ-ийн захирлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бэлтгэл ажлыг хангаж ажиллана. | | | | | 2024 оны 01 сарын 26-ны өдрийн А/40 тушаалаар батлуулан хэрэгжүүлж ажилласан.<br>2024 оны 12 сарын 5-6-ны өдрүүдэд шинжээч нарын баг бүрэлдэхүүн ирж тус төв магадлалын итгэмжлийн шалгалтанд дараах чиглэлээр амжилттай шалгууллаа:<br>- Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал<br>- Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал<br>- Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангах<br>- Үзлэг, оношилгоо, эмчилгээ<br>- Халдварын сэргийлэлт, хяналт<br>- Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ<br>- Эрүүл мэндийн байгууллагын засаглал, удирдлага, манлайлал<br>- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын удирдлага<br>- Хүний нөөцийн хөгжил<br>- Мэдээллийн удирдлага, аюулгүй байдал<br>- Тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй ажиллагаа, засвар, техникийн үйлчилгээ<br>- Барилга, инженерийн байгууламжийн аюулгүй ажиллагаа<br>- Амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ<br>- Сувилахуйн тусламж, үйлчилгээ<br>- Эмийн менежмент ба зохистой хэрэглээ<br>- Лабораторийн тусламж, үйлчилгээ<br>- Эмчилгээний хоол | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ<br>- Арьс ба арьсан доорх эслэгийн өвчний тусламж, үйлчилгээ<br>- Сэргээн засах тусламж, үйлчилгээ<br>- Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээ | |
| 16 | МУТЖҮЧ - 2.2.7<br>ЗГҮАХ – 2.1.8<br>СТ-7.1.1.6<br>Эмч, эмнэлгийн ажилчдын Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэглээг нэмэгдүүлнэ. | 1.0 | Эмч, эмнэлгийн ажилчдын Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэглээний оноо /CME/ | I-IV улирал | Эмч, эмнэлгийн ажилчдын Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийн хэрэглээ нэмэгдэж дундаж CME хэрэглээ 260 болсон байна. | Төвийн хэмжээнд нийт 35 эмч Uptodate олон улсын эмнэлзүйн удирдамжийг ашиглаж байгаа ба CME хамгийн их хэрэглээ нь 472, дунджаар 200 оноотой байна. | 100 |
| 17 | МУУХХБ-2.2.21<br>ЗГҮАХ-2.1.3.<br>СТ – 2.1.3<br>ISO 9001:2015 олон улсын чанарын менежментийн тогтолцоог магадлах аудитаар баталгаажуулна. | 2.0 | Аудитаар баталгаажуулсан гэрчилгээ | I-II улирал | ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангаж, магадлах аудитаар баталгаажуулсан байна. | Тус төв нь 2013 оноос олон улсын чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2008, MNS.ISO 9001:2010 стандартыг салбартаа анхдагчаар нэвтрүүлж жил бүр аудитаар баталгаажуулж ажиллаж байна. 2024 оны чанарын менежментийн тогтолцоог магадлах, баталгаажуулах ажлыг 12 сарын 25-ны өдөр хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Чанарын удирдлагын тогтолцооны стандартыг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын нийт 118 журам, 21 заавар, 22 арга аргачлал дотооддоо баталж мөрдөн ажиллаж байна. | 100 |
| 18 | МУУХХБ 2.2.26<br>ЗГҮАХ-2.1.3.<br>СТ 2.1.3.8 | 5.0 | | I-IV улирал | 15 чиглэлээр чанарын сургалтыг | Нийт эмч, эмнэлгийн ажилчдад15 чиглэлээр чанарын сургалтыг зохион байгуулж ажилласан. Үүнд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Нийт эмч, эмнэлгийн ажилчдад чанарын сургалтыг тогтмол зохион байгуулна. | | Сургалтад хамрагдсан ажилчдын хувь Сургалтын төрөл | | зохион байгуулж, нийт ажилчдын 90-ээс доошгүй хувь хамрагдсан байна. | ➢ ЭМДҮЗ-ийн шинэчлэсэн тогтоолтой холбоотой оношийн хамааралтай бүлэг сонгох, битүүмж гаргах заавар боловсруулан эмч нарт тарааж сургалтыг нийт эмч нарт 2 удаа зохион байгуулсан.<br>➢ Өвчний түүхийн хяналтыг сар бүр тогтмол хийж, түгээмэл гарч буй алдааг эмч нарын хурал дээр танилцуулж дахин алдаа гаргахгүй байх зорилгоор нийт 10 удаагийн сургалтыг тухай бүр зохион байгуулсан.<br>➢ 2024 оны 04-р сарын 08-ны өдөр E-health системээс ЭМДҮЗ-ийн 08-р тогтоолын 2-р шинэчлэлтэй холбоотой цахим сургалтанд төвийн нийт эмч нар, чанарын багийн гишүүд, даатгалын мэргэжилтэн болон мэдээлэл технологийн албаны инженер хамрагдсан<br>➢ Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах сэдэвт сургалтыг ЭМТҮЧАБА менежер У.Саруул сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд хичээл орсон.<br>➢ Магадлан итгэмжлэлийн шалгалтад бэлдэж нийт тасаг нэгжүүдэд чанарын шалгуурын тасралтгүй байдлыг хангаж ажиллах талаар зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан.<br>➢ Тусламж үйлчилгээний чанар, хөдөлмөр аюулгүй байдлын сургалтыг шинэ ажилчдад чиглүүлэх сургалтыг зохион байгуулдаг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Төгсөлтийн дараах сургалтын элсэлтийн чиглэлээр сурагч нарыг сургалтад хамруулдаг.<br>➢ ЭМТҮЧАБА менежер Ж.Булган Харвардын анаагахын сургуулиас зохион байгуулж буй LEADERSHIP IN MEDICINE: SOUTHEAST ASIA 2023-2024 хөтөлбөрт 2023.02.27-2024.02.29 хооронд 1 жилийн хугацаатай хамрагдан Эрүүл мэндийн манлайлал чиглэлээр мэргэжил дээшлүүлж нийт эмч, чанарын багт зөвлөмж мэдээлэл өгсөн<br>➢ ЭМХТ-ийн Магадлан итгэмжлэлийн албанаас ЭМЯ, ДЭМБ, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан “Оношилгооны аюулгүй байдал” сэдэвт сургалт, өдөрлөгт ЭМТҮЧАБА-ны дарга Ж.Булган, чанарын менежер У.Саруул, бүртгэл мэдээллийн ажилтан У.Дэлгэржаргал нар оролцов. Тус эмнэлгийн Эмнэзүйн төв лаборатори, Эмгэг судлал, Дуран, Дүрс оношилгооны тасгуудын оношилгооны аюулгүй байдлыг ханган ажиллаж буй үйл ажиллагаатай газар дээр нь танилцаж, туршлага судлав. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  <br>➢ 2024.09.20-ны өдөр ТТАХНЭ-ээс зохион байгуулсан “Оношилгооны аюулгүй байдлыг сайжруулах нь” сэдэвт сургалтанд ЭМТҮЧАБА-ны дарга Ж.Булган оролцов.<br>➢ АӨСҮТ-өөс “Чанарын үндсэн ойлголт, үзэл баримтлал, зарчмууд”, “Байгууллагын соёл” сэдэвт чанарын сургалтыг тус төвийн чанарын багийн гишүүн 13 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад зохион байгууллаа<br><br>➢ MNS ISO 19011:2020 - менежментийн тогтолцоонд аудит явуулах арга зүй сэдэвт 2 өдрийн сургалтад чанарын менежер У.Саруул, MNS ISO 9001: 2016 чанарын удирдлагын тогтолцоо - шаардлага сургалтад эрчимт эмчилгээ, яаралтай түргэн тусламжийн тасгийн эрхлэгч Д.Чанцалдулам нар хамрагдсан.<br>➢ Эрүүл мэндийн чанарын холбоооос зохион байгуулсан “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт 35 цагийн анхан шатны сургалтад сувилагч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Б.Жавхлант, бүртгэл мэдээллийн ажилтан У.Дэлгэржаргал нар тус тус амжилттай хамрагдаж төгссөн | |
| 19 | МУУХХБ-2.2.26<br>ЗГҮАХ-2.1.8<br>СТ-2.1.1.13<br>Лабораторийн шинжилгээний гадаад, дотоод хяналтын тасралтгүй байдлыг хангана. | 3.0 | Гадаад, дотоод хяналтын үнэлгээний тайлан | I-IV улирал | Лабораторийн шинжилгээний гадаад /2/, дотоод хяналтын /250/ үнэлгээний тайлан гарсан байна. | 2024 онд лабораторийн шинжилгээний дотоодын хяналт үнэлгээг 5 чиглэлээр хийсэн.<br>➢Гематологи 162 удаа<br>➢Биохими 214 удаа<br>➢Иммунологи 81 удаа<br>➢Нян судлал 240 удаа<br>➢ШЕШ 12 удаа тус тус хяналтыг хийсэн. Хяналтыг контрол chart дэвтэрт тогтмол хөтлөн хадгалж байна.<br>Лабораторийн шинжилгээний гадаад хяналтанд 5 чиглэлээр хамрагдсан:<br>➢Биохимийн гадаад хяналтанд<br>- Харьцангуй үнэлгээ: 71,85 %<br>- Үнэмлэхүй үнэлгээ: 68.15%<br>➢Гематологийн гадаад хяналтаар<br>- Харьцангуй үнэлгээ -89,17%,<br>- Үнэмлэхүй үнэлгээ - 84.17% байна.<br>   <br>➢Бактериологийн шинжилгээний чанарын гадаад үнэлгээ 90% буюу маш сайн гэсэн үнэлгээг авсан.<br>➢Цусны бүлэг, хувийн тохирооны чанарын 21 дэхь удаагийн хяналтанд амжилттай хамрагдсан.<br>- Цусны бүлэг -100% | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Хувийн тохироо -81,25%<br>➢ Цусаар дамжих халдвар В, С вирус болон серологи ДОХ-ийн шинжилгээний гадаад хяналтаар<br>- HBV-100% TP- 100%<br>- HCV-90 % HIV- 100% | |
| 20 | МУТЖҮЧ – 2.2.7<br>ЗГҮАХ – 2.1.8<br>СТ-2.1.3.4<br>Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, чанар аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж ажиллана. | 5.0 | Хийсэн хяналтын тоо<br>Арилгасан зөрчлийн тоо | I-IV улирал | Нийт 13 чиглэлээр 25 удаагийн хяналт хийж, илрүүлсэн зөрчлийг бүрэн арилгасан байна. | ЭМТҮЧАБА-ны 2024 оны эрсдэлийн төлөвлөгөөний дагуу сар бүр эмнэл зүйн тусламж, үйлчилгээг түүвэрлэн хянаж байна. Үүнд:<br>1. 2024 оны 11 сарын байдлаар нийт 4829 өвчний түүхээс 98 түүхийг түүврийн байдлаар хянасан. ЭМДҮЗ-ийн 12 тогтоолын дагуу эдгээр өвчний түүхийн 68.4% болох 67 өвчний түүх шалгуур хангаагүй тул зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгсөн.<br>2. ЭМДҮЗ-ийн 6 тогтоолын түр шалгуурын дагуу яаралтай тусламжийг хянаж байна. 2024 оны 11 сарын байдлаар нийт 3798 ЯТХ бүртгэгдсэнээс түүврийн байдлаар 108 яаралтай тусламжийн хуудсыг хянасан ба шалгуур хангаагүй 93,5% болох 101 ЯТХ-ын зөрчлийг арилгасан.<br>3. Амбулаторын үзлэгийн хяналтын хүрээнд:<br>➢ 1 дүгээр сарын 20-ны байдлаар амбулаторийн 14 эмчийн үзлэгт хяналт хийхэд нийт 5494.5 үзлэг хийгдэхээр төлөвлөснөөс 4609 үзлэг хийгдэж 83.8% гүйцэтгэлтэй ажиллаж байна.<br>➢ 2 дугаар сарын 20-ны байдлаар амбулаторийн 14 эмчийн үзлэгт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт хийхэд нийт 6887 үзлэг хийгдэхээр төлөвлөснөөс 6259 үзлэг хийгдэж 90.8% гүйцэтгэлтэй ажиллаж байна.<br>Эмнэлгийн тусламж үйлчилгээг хянаснаар эмнэлзүйн тусламж, үйлчилгээний чанар сайжирч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилж, өмнөх онтой харьцуулахад Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн төлбөрийн хасагдлын дүн 24,5%-иар багассан үр дүнтэй ажиллаж байна. | |
| 21 | ЗГҮАХ-2.1.10.<br>СТ-2.1.3.5<br>Үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэнэ. | 1.0 | Хугацаанд нь шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо | I-IV улирал | Үйлчлүүлэгчийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг 100 хувь хугацаанд нь шийдвэрлэсэн байна. | Иргэний өргөдөл, гомдлыг аман, биечлэн, утсаар, цахимаар, 11-11, бичгээр, санал хүсэлтийн дэвтэрээр хүлээн авч бүртгэн, хариу арга хэмжээ авч шийдвэрлэн ажилладаг. Улирал бүр иргэний өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн тайланг ЭМХТ хүргүүлдэг. 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 52 буюу санал, хүсэлт - 1, өргөдөл, гомдол – 49 , талархал - 1 хүлээн авч, өргөдөл, гомдлыг 100% шийдвэрлэн ажилласан.<br>2024 оны эхний 11 сарын байдлаар амбулаториор 85,989 үйлчлүүлэгч, тасагт 4473 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлсэн байна. Үүнээс түүврийн аргаар авч үнэллээ. Судалгаанд 2024 онд АӨСҮТөвөөр үйлчлүүлсэн 1205 хэвтэн эмчлүүлэгч, 1120 амбулаторын үйлчлүүлэгч, нийт 2325 үйлчүүлэгчийг сэтгэл ханамжийн судалгаанд хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Яаралтай түргэн тусламжийн тасгаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа – 82, Маш сайн - 76,8%, Сайн - 17,1%.<br><br><br>Амбулаториор үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа – 64 (Маш сайн болон сайн)<br><br><br>1313.mn платформоор дамжуулан 268 иргэн сэтгэл ханамжийн судалгаанд оролцсоноос маш сайн (47.4%), сайн (33.9%), дунд (36.2%) үнэлгээг өгсөн байна.<br><br><br>Төвийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж дунджаар 87% байна. Цахим бүртгэлийн ажилтнуудын түргэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шуурхай, найрсаг үйлчилгээг үйлчлүүлэгчдийн 91% нь сайн үнэлсэн.<br>Лабораторийн тасгийн сэтгэл ханамжийн судалгааны дүн:<br>➢ 1-р улирал: Нийт 57 хүн оролцсоноос 68% нь анх удаа, 32% нь 2 ба түүнээс дээш удаа үйлчлүүлсэн. Эмэгтэйчүүд 68.5%, эрэгтэйчүүд 31.5%-ийг эзэлж, үйлчилгээний ихэнх хэсэгт 85%-аас дээш сайн үнэлгээ өгчээ.<br>➢ 2-р улирал: Нийт 63 хүн оролцсон. Үйлчлүүлэгчдийн 85.5% нь санал хүсэлт хүлээн авч, асуудлыг шуурхай шийдвэрлэхэд сайн үнэлгээ өгсөн.<br>➢ 3-р улирал: Нийт 50 хүн оролцсон. Үйлчлүүлэгчдийн 94% нь тасгийн соёлыг сайн гэж үнэлсэн ба гомдол гарсан тохиолдол бүртгэгдээгүй. | |
| 22 | МУТЖҮЧ – 2.2<br>ЗГҮАХ – 2.1<br>СТ – 2.1.3.16<br>Дотоод хяналтын төлөвлөгөөг шинэчилж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | 10.0 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | I-IV улирал | Дотоод хяналтын нэгжийн төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувь биелсэн байна. | Төвийн захирлын 2023 оны А-34 тоот тушаалаар дотоод хяналтын ажиллах журам, баг бүрэлдэхүүнийг шинээр томилж баталсан. 2024 онд дотоод хяналтын чиглэлээр 7 ажил төлөвлөж хэрэгжүүлсэн. Үүнд:<br>1. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээг хийхэд 7 зорилго 11 зорилтын хүрээнд 42 ажил төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэл 96.8 хувь байна.<br>2. Байгууллагын 2024 оны хагас жилийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 7 зорилго 8 зорилгын хүрээнд 42 ажил | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэл 85 хувь байна.<br>3. Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны дотоод журмын хэрэгжилтэнд хяналт үнэлгээг хийхэд хэрэгжилт 95 хувь байна.<br>4. Гэрээт 11 байгууллагуудын гэрээний хэрэгжилтэнд хяналт үнэлгээг хийхэд хэрэгжилт дунджаар 98 хувь байна.<br>5. Ажилчдын албан тушаалын тодорхойлолтод хяналт хийж 25 ажилчдын АТТ-ыг шинэчлэх зөвлөмж шаардлагыг ХНА-нд өгсөн.<br>6. Байгууллагын 2024 оны жилийн гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд 7 зорилго 8 зорилгын хүрээнд 42 ажил төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэл 94.7 хувь байна.<br>7. Байгууллагын 2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжилт 94 хувь байна<br>Хийгдсэн хяналт үнэлгээний дагуу тайлан, дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчлийн арилгах арга хэмжээг тухай бүр авч ажилладаг. | |
| 23 | МУУХХБ-2.2.26<br>ЗГҮАХ-2.1.8<br>СТ-2.1.3.4, 2.1.3.12<br>Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтын дагуу өгсөн албан шаардлагыг биелүүлж, | 25.0 | Албан шаардлагын хэрэгжилтийн хувь | I-IV улирал | Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалт, албан шаардлагыг 100 хувь биелүүлсэн байна. | ➢ ЭМДЕГ-аас нийт хэвтэн эмчлүүлэгчдийн өвчний түүхийн 15%-ийг түүврийн аргаар чанарын хяналт хийн санхүүжилтийг олгодог. ЭМД-аас өгсөн зөвлөмжийг тухай бүр хэрэгжүүлэн, алдаа зөрчлийг арилгаж ажилладаг. Энэ оны байдлаар нийт 98 өвчний түүхэнд хяналт хийсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжилтийг хангаж ажиллана. | | | | | ➢ Стандарт хэмжил зүйн газрын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 12/30 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг арилгах албан шаардлагын дагуу хэмжих, хэрэгслийн шалгалт баталгаажуулалт хоорондын хугацаа, нэгж хэмжүүр шалгах нормд заасан хугацаанд ээлжит баталгаажуулалтад үе шаттай бүрэн хамруулж, баталгаатай хэмжих хэрэгслийг ашиглаж байна. Мөн инженер техникийн ажилтнуудыг хэмжил зүйн салбарын сургалтад хамруулж чадавхжуулахаар төлөвлөж байна. | |
| ***Зорилт 3.2 Эмнэлгийн халдвар, хамгаалал, аюулгүй байдлыг хангах*** | | | | | | | |
| 24 | МУУХХБ – 2.2.2<br>МУТЖҮАЧ – 2.2.1<br>СТ – 2.1.5<br>Эмнэлгийн ажилчдыг дархлаажуулалтанд хамруулна. /ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албатай хамтран ажиллах/ | 10.0 | Дархлаа тогтцыг үзсэн ажилчдын тоо<br>Дархлаажуулалтад хамрагдсан ажилчдын тоо | I-IV улирал | Эмч, эмнэлгийн ажилчдыг дархлаажуулалтанд бүрэн хамруулсан байна. | ➢ АӨСҮТ нь SAS лабораторитой гэрээ байгуулан 2024 оны 06 дугаар сард дархлаажуулалтад хамрагдсан ажилчдын судалгааг гаргаж дархлаа тогтоцын шинжилгээнд нийт 79 эмч ажилчдыг хамруулсан.<br>➢ Эмнэлгийн нийт хамрагдвал зохих 134 эмч ажилчдаас В вирусийн эсрэг 3 тун вакцинд 132 эмч ажилчид бүрэн хамрагдсан. Хамрагдалтын хувь- 98,5%, 2 ажилтан татгалзсан.<br>➢ Томуугийн дархлаажуулалтад нийт хамрагдвал зохих 134 ажилчдаас 75 ажилтан хамрагдсан байна. Хамрагдалтын хувь 55,9%<br>➢ Улаанбуханы дархлаажуулалтад нийт хамрагдвал зохих 134 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилчдаас хамрагдсан 67 ажилтан хамрагдсан байна. Хамрагдалтын хувь -50%. | |
| 25 | МУУХХБ – 2.2.2<br>МУТЖҮАЧ – 2.5.4<br>СТ – 2.1.6.3<br>Эмнэлгийн орчны эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж ажиллана. | 3.0 | Агаар болон арчдасын шинжилгээ авсан тоо<br>Илрүүлсэн зөрчлийн тоо | I-IV улирал | Эмнэлгийн эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангаж ажилласан байна.<br>Илрүүлсэн зөрчлийг бүрэн арилгасан байна. | ➢ Тархвар судлаач эмчийн дотоод хяналт үнэлгээ хийх төлөвлөгөөт графикийн дагуу тасаг нэгжүүдэд багаж хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, ариутгалын үйл ажиллагааг үнэлэх үнэлгээг нийт 3 удаа, гарын эрүүл ахуйн нөхцөл бүрдсэн байдалд 10 удаа, угаалгын хэсгийн үйл ажиллагаанд хийх үнэлгээг нийт 2 удаа, өвчтөний өрөөнд өдөр тутам хийгдэх цэвэрлэгээг үнэлэх үнэлгээг нийт 5 удаа, цэвэрлэгээний чанарт дотоод хяналтыг нийт 5 удаа, ажилбарын өрөөнд хийгдэх цэвэрлэгээний үнэлгээг нийт 2 удаа , хог хаягдлын менежментийн үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу тус тус нийт 27 удаа хяналт үнэлгээг хийсэн<br>➢ Эмнэлгийн байнгын угаалга цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хянах зорилгоор эрүүл зүйн нян судлалын шинжилгээт хяналтыг 2 удаа хийсэн, /арчдас -58 ширхэг/<br>➢ Зөөврийн дезкамертай болсноор гудас, хөнжлийг озоноор хуваарийн дагуу тогмол ариутгаж байна.<br> | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Клиникийн тасаг, нэгжүүд өдөр тутам эмнэлгийн тоног төхөөрөмж хаалганы бариулыг детерж аниос 0,5% уусмалаар халдваргүйжүүлэн цэвэрлэж, 7 хоногт их цэвэрлээг 2 удаа, агаарын ариутгалыг графикийн дагуу хийж байна.<br>➢ ХСХАлбагаас тасаг нэгжүүдэд цэвэрлэгээний эрсдлийн бүсийн тэмдэг тэмдэглэгээг байршуулсан.<br>  <br>➢ Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай А/348 захирамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 12-ний өдөр эмнэлгийн гадаад орчны их цэвэрлэгээг зохион байгуулсан. Нийт 92 ажилчид идэвх санаачилгаатай оролцож их цэвэрлэгээнээс гарсан ахуйн хог хаягдлыг СБД-ын ТҮК-д хүлээлгэн өгч ачуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | |  <br>➢ Эмнэлгийн хүүхдийн тасаг, насанд хүрэгчийн 1, 2 дугаар тасагт 1200 м2 талбайг, барилгын дээврийн хөндийд 1200 м.кв талбайд их цэвэрлэгээ хийж шавьжгүйтгэл ариутгал хийсэн. | |
| 26 | МУУХХБ – 2.2.2<br>МУТЖҮАЧ – 2.2.1<br>СТ – 2.1.6.3, 3.1.3.5<br>Эмнэлгийн ажилчдыг жилд нэгээс доошгүй халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байна. | 5.0 | Үзлэг, оношлогоо шинжилгээнд хамрагдсан ажилчдын хувь | III улирал | Эмч, эмнэлгийн ажилчдыг халдвар илрүүлэх үзлэг, оношлогоо шинжилгээнд 100% хамруулсан байна. | ➢ 2024 оны 06 дугаар сард эмнэлгийн эмч ажилчдад В, С, гепатит, тэмбүү, ХДХВ халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан. Нийт хамрагдвал зохих 137 эмч ажилчдаас 117 эмч ажилчид хамрагдсан байна. Хамрагдалтын хувь – 85,4% байна.<br>➢ Мөн эмнэлгийн резидент эмч нарыг В, С, гепатит, тэмбүү, ХДХВ, халдвар илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан. Нийт хамрагдвал зохих 29 резидент эмч нараас 16 резидент эмч хамрагдсан байна. Хамрагдалтын хувь – 55% байна.<br>➢ Метициллинд тэсвэртэй стафилококк ауриус /MRSA/ илрүүлэх шинжилгээнд нийт хамрагдвал зохих 137 эмч ажилчдаас 93 эмч ажилчид хамрагдсан байна. Хамрагдалтын хувь – 67,8% байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗОРИЛГО 4. ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БАЙЖ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| ***Зорилт 4.1 Арьс харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр чадварлаг мэргэшсэн хүний нөөцөөр хангах*** | | | | | | | |
| 27 | МУТЖҮЧ - 2.2.8<br>ЗГҮАХ - 2.1.9.<br>СТ - 3.1.1.1<br>2023-2025 оны хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | 10.0 | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | I-IV улирал | Тухайн жилийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна. | 2021-2024 оны хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн 3 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажилласан.<br>➢ Эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний сул, эзгүй ажлын байрыг хангах үе шаттай арга хэмжээ авч хүний нөөцийн хангалтын хувь 98%-тай ажиллаж байна.<br>➢ Эмч, эмнэлгийн мэргэжилтний ажлын байрны дүн шинжилгээ хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд чанар аюулгүй байдлын үйл ажиллагааны оролцоог тодорхой тусган эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, тасаг албадын дарга нарын албан тушаалын тодорхойлолтод 7-8 зорилтыг, бусад байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах туслан гүйцэтгэх албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтод 4 зорилтын хүрээнд нийт 52 албан тушаалын тодорхойлолт шинэчлэн батлуулсан.<br>➢ Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу төвийн батлагдсан орон тооны 4%-ийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хангаж ажиллаж байгаа. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Тус онд мэргэшүүлэх сургалтад нийт 12 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан:<br>- Эмнэл зүйн харшил судлал-1<br>- Арьсны эмгэг судлал -2<br>- Арьсны мэс засал судлал -1<br>- Арьсны сувилахуй-6<br>- Био анагаахын мэргэжилтэн-1<br>- Мэс заслын сувилахуй-1<br>➢ Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардалаар гадаадад 8 ажилтан сургалтанд хамрагдсан:<br>- Австри улсын Зальцбург хотод Австри Америкийн сангийн дэргэдэх Open medical institute-ийн 2024 оны Арьс судлалын семинарт ЭМТҮЧАБА-ны эрсдлийн менежер У. Саруул<br>- ОХУ-ын Анагаахын шинжлэх ухааны доктор Г.Н.Габричевскийн нэрэмжит Эпидемиологи, микробиологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан Мачарадзе Дали Шотаевна “Хүнсний харшлын эмнэлзүй, оношилгоо эмчилгээ, урьдчилан сэргийлэлт” сэдэвт цахим сургалт<br>- Бээжингийн Их сургуулийн Өвөр Монголын салбар Хавдрын эмнэлэг, эмгэг судлалын тасагт арьс, эмгэг судлаач эмч Д.Дэлгэрзаяа төрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санхүүжилтээр 14 хоног суралцсан<br>- ЭМЯ-аас зохион байгуулж буй Харвардын Их Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрт 1 ажилтан, 2023-2024 онд амжилттай хамрагдаж төгссөн бол 2024-2025 онд дахин 1 ажилтан хамрагдан суралцаж байна. /тэтгэлэгээр/<br>- ОХУ, Дорно дахины Сибирийн их сургуульд ургамлын харшил судлалын чиглэлэээр ажлын байрны дагалдан сургалтанд АУ-ны поктор С.Байгалмаа, ургамал судлаач П.Минжбадрах нар эмч, мэрэгжилтэн<br>- 2024.04.09-.2024.05.09 хооронд 1 сарын хугацаатай, клиникийн 2-р тасгийн эхрлэгч эмч Ж.Аззаяа, ЭЭЯТ-ийн эрхлэгч эмч Д.Чанцалдулам эмч нар хамтын гэрээний дагуу Тайван улсын Цэргийн төв эмнэлэгт мэргэжил дээшлүүлсэн.<br>- Тайвань улс, Tri- service general hospital Арьсны тасаг, Эмгэг судлалын тасагт их эмч Э.Дэлгэрзаяа 3 сарын хугацаатай fellow эмчээр ажиллаж байна<br>- БНСУ, Medical Skin Care Center 2 эмч мэргэжилтэн дээшлүүлэх сургалтад хамрагдаж орчин үеийн дэвшилтэт технолги, эмчилгээ оношилгоог | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэвтрүүлэхээр суралцсан ахицтай байна<br>- БНХАУ-н Бээжингийн Их сургуулийн Өвөр Монголын салбар Хавдрын эмнэлэг, эмгэг судлалын тасагт 1 эмч<br>➢ Эмнэлзүйн харшил судлал, эмчилгээний гоо засал судлал, арьсны мэс засал судлал, эрүүл мэндийн бодлого удирдлага гэсэн 4 чиглэлээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн.<br>➢ Жил бүр эрдмийн цол, мэргэжлийн зэрэгтэй эмнэлгийн мэргэжилтний тоог нэмэгдүүлэхэд байгууллагаас дэмжлэг үзүүлдэг.<br>Эрдмийн цол, мэргэжлийн зэрэг хамгаалсан эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүд:<br>- АУ-ны доктор-1<br>- Клиникийн профессор-2<br>- Зөвлөх-2<br>- Магистр-10<br>- Ахлах-15<br>- Тэргүүлэх-12<br>- Сувилахуйн магистр–2 суралцаж байна/ | |
| 28 | МУУХХБ – 2.2<br>МУТЖҮЧ - 2.2.2<br>СТ – 3.1.6.6, 8.1.5.3<br>Эмч, эмнэлгийн ажилчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо хийхэд бусад эрүүл мэндийн | 15.0 | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан ажилчдын хувь | III-IV улирал | Урьдчилан сэргийлэх үзлэгт нийт ажилчид 100 хувь хамрагдсан байна. | Эмч, эмнэлгийн ажилчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоонд тогтмол хамруулж урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээг авч ажилладаг.<br>➢ Ажлын байрны аюулгүй байдал, эрүүл мэндийн аян хүрээнд лабораторийн тасаг нь нийт ажилчдад өтгөнд хеликобактери | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагатай хамтран ажиллана. | | | | | илрүүлэх шинжилгээг 64 /32,1%/ ажилтанд хийсэн<br>➢ Элэгний B,C илрүүлэх шинжилгээг нийт 117 ажилтанд,16 резидент эмч нарт хийхэд нийтдээ 12 ажилтанд C вирус ээрэг, 3 ажилтанд B вирус ээрэг гарсан. Нийт хамрагдвал зохих 137 эмч ажилчдаас 117 эмч ажилчид хамрагдсан байна. Хамрагдалтын хувь- 85,4% байна.<br>2024 оны 06 дугаар сард SAS лабораторитой гэрээ байгуулан дархлаажуулалтад хамрагдсан ажилчдын судалгааг хийж дархлаа тогтцын шинжилгээнд нийт 73 эмч ажилчдыг хамрууллаа. Хамрагдалтын хувь- 53.2% байна.<br>➢ Бундан зүрх охид эмэгтэйчүүдийн эмнэлэгтэй гэрээ байгуулан 2024 оны 06 сарын 04 – 07-ны өдрүүдэд эмэгтэйчүүдийн үзлэг, зөвөлгөө, мазокийн шинжилгээ болон умайн хүзүүний эсийн шинжилгээнд нийт эмэгтэй 81 /65.3%/ ажилтан хамрагдсан. Үүнээс 9 ажилтан умайн хүзүүний хавдрын урьдал өвчнөөр оношлогдоод байна. Эсийн шинжилгээнд өөрчлөлттэй гарсан ажилчид Хавдар судлалын төвд эдийн шинжилгээнд орж хавдрын эмчийн зөвөлгөөг авч хяналтанд орсон.<br>➢ Ажилчдыг ХДХВ болон тэмбүүгийн шинжилгээнд хамруулсан. Нийтдээ 117 эмч, ажилчид хамрагдсан. Хамрагдалтын хувь- 85.4%. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Метициллинд тэсвэртэй стафилококк ауриус /MRSA/ илрүүлэх шинжилгээнд нийт 93 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан. Хамрагдалтын хувь-67,8% байна. MRSA илрүүлэх хамрын арчдасын шинжилгээнд нийт 35 хүнд илэрсэн тул эрүүлжүүлэх арга хэмжээг авав. | |
| 29 | МУУХХБ – 2.4.20<br>МУТЖҮЧ 2.4.2<br>СТ- 3.1.3.1, 3.1.3.6<br>Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадавхийг бэхжүүлнэ. | 3.0 | Практикт нэвтрүүлсэн үр дүн<br>Хэвлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүллийн тоо | I-IV улирал | Арьс, харшлын чиглэлээр шинээр судалгаа шинжилгээний ажил хийж, үр дүнг практикт нэвтрүүлсэн байна. | Төвийн эмч, судлаачдын нийт 27 эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл хэвлэн нийтлэгдсэн. Үүнээс арьс, харшлын чиглэлээр 26, бусад чиглэлээр 1. Эдгээр нь тус төвд хийгдсэн оношилгоо, эмчилгээний үр дүн ба практикт бүрэн нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр төлөвлөж буй судалгааны ажлууд болно.<br>Гадаадын сэтгүүлд хэвлэж нийтлүүлсэн:<br>➢ Б.Батцэцэг, Б.Хандсүрэн нарын “Teledermatology: cost-benefit analysis of store-and-forward application in mongolia” august 2024, journal of investigative dermatology<br>➢ Т.Баярмаа, С.Байгалмаа нарын “Анализ распространённости и опыт лечения аллергических заболеваний респираторного тракта в Монголии”<br>Гадаадад хэлэлцүүлсэн илтгэл :<br>➢ 2024.03.07 нд Westin San Diego Bayview-д охион байгуулагдсан АНУ-ын Хавьтал харшлын дерматитийн нийгэмлэгийн хуралд эмнэлзүй эрхэлсэн дэд захирал Б.Батцэцэг илтгэл хэлэлцүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 30 | МУУХХБ – 2.2.12<br>МУТЖҮЧ 2.2<br>СТ – 8.1.5.4<br>Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллана. | 5.0 | Гэрээний хэрэгжилтийн хувь | I-IV улирал | Гадны орнуудтай байгуулсан хамтын гэрээний хэрэгжилтийг хангаж, хамтарч ажилласан байна. | Тайвань улсын Юн рунг эмнэлэгтэй 2023-2026 оны хугацаанд хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.<br>➢ Тайвань улс, Юн Рунг, Цэргийн төв эмнэлэгт клиникийн II тасгийн эрхлэгч Ж.Аззаяа, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч Д.Чанцалдулам нар 1 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлсэн.<br><br>➢ Тайвань улс, Юн Рунг, Tri- service general hospital арьсны тасаг, эмгэг судлалын тасагт 3 сарын хугацаатай fellow эмчээр лабораторийн тасгийн их эмч Д.Дэлгэрзаяа суралцаж байна.<br>БНСУ, Medical Skin Care Center-тэй 2024-2025 онд 1 жилийн хугацаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний зорилго нь арьс, харшил, эмчилгээний гоо заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтад эмч, мэргэжилтнүүдийг сургах.<br>➢ 2024 онд нийт 3 эмч гэрээний дагуу 1-3 сарын сургалтад хамрагдсан.<br>➢ БНСУ, Medical Skin Care Center эмнэлэгт их эмч Б.Энхсайхан, сургалтын арга зүйч, арьсны эмч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | А.Болормаа нар 2024 оны 11 сараас 1 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж байна. | |
| ***Зорилт 4.2 Эмч, эмнэлгийн ажилчдын нийгмийн баталгааг сайжруулж, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллах*** | | | | | | | |
| 31 | МУУХХБ – 2.2.22<br>МУТЖҮЧ-2.2.8<br>СТ-3.1.4.4<br>Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын дагуу ажилчдын урамшууллыг олгоно. | 640.0 | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн үнэлгээ | I-IV улирал | Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуурын дагуу эмч, эмнэлгийн ажилтныг үнэлж урамшууллыг олгосон байна. | Засгийн газрын тогтоолын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу улирал тутам гүйцэтгэлийн үнэлгээг хийж урамшуулал олгосон:<br>➢ 1-р улиралд 105 ажилтанд 72,130,593 төгрөг<br>➢ 2-р улирал 130 ажилтанд 87,499,959 төгрөг<br>➢ 3-р улирал 133 ажилтанд 80,934,654 төгрөгний урамшуулал олгосон.<br>2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 240,565,206 төгрөгний үр дүнгийн урамшууллыг эмч, эмнэлгийн ажилчдад олгосон байна. | 100 |
| 32 | МУТЖҮЧ-3.2<br>СТ-3.1.6.1<br>Ажилчдыг орон сууцтай болгох орон сууцны зээлд хамруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ. | 50.0 | Орон сууцны зээлд хамруулсан ажилтны тоо | III, IV улирал | Ажилчдыг орон сууцтай болгох орон сууцны зээлд хамруулах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна. | Хас банк, Худалдаа хөгжлийн банктай хамтран ажиллах гэрээ байгуулж төвийн албан хаагчдад ипотекийн зээлийн хүсэлтийг дараалалгүй болгох, цалингийн зээлийн хүүг зөвхөн төвийн албан хаагч нарт банкны хүүгээс 2%-аар бага нөхцөлөөр олгох зэрэг нөхцөл тусган ажиллаж байна. | 50 |
| ***Зорилт 4.3 Эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулах*** | | | | | | | |
| 33 | МУТЖҮЧ – 2.2.8<br>СТ-3.1.5.6<br>Ажилчдын ёс зүй, сахилга хариуцлага, соён гэгээрүүлэх | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь Ёс зүйтэй холбоотой | I-IV улирал | Ажилчдын ёс зүй, сахилга хариуцлага, соён гэгээрүүлэх | Ажилчдын ёс зүй, сахилга хариуцлага, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хэрэгжүүлсэн: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | нотлогдсон гомдлын тоо | | ажлын төлөвлөгөө бүрэн хэрэгжиж, харилцаа хандлага дээшилсэн байна. | ➢ Нарны шаргал тусгал НҮТББ-ээс зохион байгуулсан ”Эмч, эмнэлгийн мэргэжилтний эрх, ёс зүйн шинэ ойлголт” сэдвийн /1,0 кредит/ сургалтанд 64 эмч, эмнэлгийн ажилтан, резидент эмч нарыг хамруулсан.<br>➢ “Эмч, эмнэлгийн ажилтны ёс зүйн хэм хэмжээ” чиглүүлэх сургалтын 4 цагийн лекцийг Ёс зүйн хорооны дарга Б.Баярмаа 2022-2024 онд шинээр элсэн суралцаж буй 29 нийт резидент эмч нарт орсон<br>➢ Резидент эмч нарын багц цагийн сургалтад багтдаг ёс зүйн кредиттэй сургалтыг зохион байгуулсан<br>➢ “Ёс зүйг чадавхжуулах нь” уриан дор “Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа, хандлага” сэдэвт сургалт, өдөрлөгийн хүрээнд 10 сарын 15-ны өдрөөс 10 сарын 21-ний өдрийн хугацаанд 8 чиглэлийн сургалт, мэдээллийг давхардсан тоогоор 133 төвийн нийт албан хаагчид, резидент эмч нар болон 3 тасгийн 38 хэвтэн эмчлүүлэгч, үйлчлүүлэгч нарт хүргэн амжилттай зохион байгуулсан.<br>➢ Байгууллагад мөрдөх хууль журам, дотоод журам, тушаал шийдвэр, эмнэлгийн мэргэжлийн хариуцлага, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагын лекц хичээлийг Ёс зүйн хорооны нарийн бичиг, сувилахуйн төрөлжсөн мэргэжлийн сувилагч нар болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр ажилд орсон сувилагч нарт зохион байгуулсан. | |
| 34 | МУУХХБ – 5.3.21<br>МУТЖҮЧ – 5.6.2<br>СТ – 8.1.2<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | - | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь<br>Авлига ашиг сонирхлын зөрчлийн нотлогдсон гомдлын тоо | I-IV улирал | Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжиж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна. | Байгууллагын ажилчдад авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх төлөвлөгөөний дагуу АТГ-ын мэргэжилтнээр сургалт зөвлөгөөг хүргэж, авилгын хор хөнөөл сэдвээр брошур бэлдэн төвийн ажилчид болон үйлчлүүлэгчдэд тараасан. Авилгын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчилах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулж ажилчид, үйлчлүүлэгчдэд мэдээллээр хангаж, гарын авлагыг тараасан. ’Авилгын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох’’ судалгааг төвд хэвтэн эмчлүүлж байгаа болон амбулаториор үйлчлүүлж байгаа иргэдээс авч судалгааны дүн маш бага эрсдэлтэй, үйлчлүүлэхэд чирэгдэл хүндрэл бага гэж судалгаанд оролцогчдын ихэнх нь өгсөн. | 100 |
| **ЗОРИЛГО 5. ДЭВШИЛТЭТ ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙГ НЭВТРҮҮЛЭХ** | | | | | | | |
| 35 | МУУХХБ – 2.2.28<br>ЗГҮАХ-2.1.4<br>СТ – 5.1.2<br>Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана /мэс засал, лаборатори, сургалтын, бусад/ | 30.0 | Шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн ашиглалт | I-IV улирал | Лазер эмчилгээний тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | Лазер эмчилгээний тоног төхөөрөмжийг 2025 онд авахаар төлөвлөөд байна. | 50 |
| | | 30.0 | | | Бусад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай дараах тоног төхөөрөмжөөр тасаг нэгжийг хангасан:<br>1. Лабораторийн тасагт:<br>- Иммунологийн аппарат /Microplate/ | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Шээсний анализатор /UC1000 Main complete/<br>- Зөөврийн кварц<br>- Микроскоп камер<br>2. Эмчилгээний гоо заслын тасагт шинээр<br>- Үс оношлогооны аппарат<br>- Үсний булцуу түүдэг багаж<br>3. Эмийн сан:<br>- Ус нэрэгч аппарат<br>4. Угаалга, ариутгал<br>- Дезкамер<br>5. Бусад тасаг нэгжүүдэд арьсны эхоны датчик, сувилагчийн тэргэнцэр, дуслын хөл шинээр авсан. | |
| 36 | МУУХХБ – 2.2.28<br>МУТЖҮЧ – 2.4.7<br>СТ-5.1.2.13<br>Мэдээлэл технологийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлнэ. | 130.0 | Нэмэгдүүлсэн серверийн үйлчилгээ | I-IV улирал | Мэдээлэл технологийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлж бүрэн шинэчилсэн байна. | Мэдээлэл технологийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ЭМЯ-ны 150 сая төгрөгний санхүүжилтээр 2 сервер худалдан авах тендерийг 2024 оны 11 дүгээр сард зарласан.<br>Байгууллагын серверийг бүрэн шинэчилсэнээр дотоод сүлжээнд холбогдсон компьютер, утас зэрэг төхөөрөмжүүдийн аюулгүй байдал, өгөгдлийн найдвартай хадгалалт, нэгтгэсэн тохиргоо үүсгэх чадамж, дотоод сүлжээний удирдлага, санхүү өгөгдлийн шуурхай дамжуулалт, нэгтгэсэн платформийн зохицуулалт сайжрана. | 90 |
| 37 | МУУХХБ – 2.2.28<br>МУТЖҮЧ – 2.4.7<br>СТ-5.1.2.14 | 60.0 | Системд холбогдсон компьютерийн тоо | I-IV улирал | Мэдээлэл технологийн аюулгүй байдал бүрэн | Тус оны 12 дугаар сараас мэдээлэл технологийн серверийн хүчин чадал нэмэгдэж шинэчлэгдсэнээр байгууллагын 80 компьютерыг VM | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Active director domain controller буюу хэрэглэгчийн нэгдсэн удирдлагын систем нэвтрүүлнэ. | | | | хангагдсан байна. | буюу виртуал машинд холбож, тасаг нэгж бүрээр задлан зураглал зурж 2 толгой компьютерээс хянан ажилуулах нөхцөлөөр хангаж, мэдээллийн сайн туршлагын дагуу зураглалыг бэлдэхээр төлөвлөөд байна. Актив директор домайн контролер буюу хэрэглэгчийн нэгдсэн удирдлагын системээр хэрэглэгчийн нэр нууц үгийг хадгалах, мөн өөр бусад олон төрлийн системтэй холбогдон ажилладгаараа давуу талтай юм. | 90 |
| **ЗОРИЛГО 6. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДЭД ЭЭЛТЭЙ, АЮУЛГҮЙ ОРЧНЫГ БҮРДҮҮЛЭХ** | | | | | | | |
| 38 | МУУХХБ - 2.2.27<br>СТ – 5.1.12<br>Лабораторийн тасагт засвар үйлчилгээг хийж тохижуулна. | 250.0 | Засвар үйлчилгээ хийж ашиглалтад оруулсан тасаг | II, III улирал | Лабораторийн тасагт бүрэн засвар үйлчилгээг хийж тохижуулсан байна. | Тус төвийн лабораторийн тасгийг үйлчлүүлэгчдэд тав тухтай, аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоор ЭМЯ-ны 412 сая төгрөгний санхүүжилтээр иж бүрэн засвар үйлчилгээг хийж тохижуулж 2024 оны 11 дүгээр сард улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан. Тус засвар үйлчилгээгээр нийт 600 мкв бүхий 15 өрөө, коридорын хана, тааз, шал, цонх, агааржуулалтын систем, гэрэлтүүлгийг бүрэн шинэчилсэн. Мөн өрөөний угаалтуурнуудыг мэдрэгчтэй болгон суурилуулсан.   | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | МУУХХБ-2.2.27<br>СТ – 5.1.12, 8.1.3.12<br>Эмчилгээний гоо сайхан, нөхөн сэргээх тасагт засвар үйлчилгээг үе шаттай хийж тохижуулна. | 150.0 | Засвар үйлчилгээний гүйцэтгэлийн хувь | IV улирал | Эмчилгээний гоо сайхан, нөхөн сэргээх тасагт шаардлагтай засвар үйлчилгээг хийж тохижуулсан байна. | Эмчилгээний гоо сайхан, нөхөн сэргээх тасгийн мэс заслын тасаг, эмчилгээний 4 өрөөнд иж бүрэн засвар үйлчилгээг хийж тохижуулав.<br>  | 100 |
| **ЗОРИЛГО 7. ХАГАС БИЕ ДААСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, САНХҮҮГИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ АЖИЛЛАХ** | | | | | | | |
| 40 | МУТЖҮЧ-2.2.5<br>СТ – 8.1.1<br>ЭМДЕГ-тай гэрээ байгуулж хамтарч ажиллана. | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | I-IV улирал | ЭМДЕГ-тай байгуулсан гэрээг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. | 2024 онд нийт 11 төрлийн 35 оношийн хамааралтай бүлгээр ЭМДЕГ-тай гэрээ байгуулж арьс, харшлын өвчний тусламж үйлчилгээг үзүүлж байна. Тус оны 11 сарын байдлаар нийт 4,786,755,992 төгрөгийн санхүүжилтийг авсан. Үүнээс үзлэг 19%, оношлогоо шинжилгээ 21%, эмийн эмчилгээ 44%, өндөр өртөгт 5%, эрчимт эмчилгээ 2%, өдрийн эмчилгээ 2%, яаралтай тусламж 6% эзэлж байна. | 100 |
| 41 | ЗГҮАХ-1.1.9<br>СТ – 8.1.1.3<br>Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана. | - | Аудитын дүгнэлт | I-IV улирал | Аудитын дүгнэлтээр Хэмнэлтийн тухай хуультай холбоотой зөрчилгүй ажилласан байна. | Төсвийн сахилга, хариуцлагыг дээшлүүлж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаж байна. Байр ашиглалттай холбоотой урсгал зардалд 18.688.496 төгрөг, хангамж, бараа материалын зардалд 6.720.383 төгрөг, норматив зардалд 462.439.412 төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 149.142.244 төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээнд 33.835.531 төгрөгийн хэмнэлттэй ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 42 | ЗГҮАХ-2.1.7<br>СТ – 4.1.1.1<br>Шаардлагатай өртгийг шинээр тооцож саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. | - | Шинээр тооцсон өртгийн тооцоо | I-IV улирал | Шаардлагатай өртгийг шинээр тооцож саналыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Тус төвөөс ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газар, ЭМДЕГ-т амбулаторийн үзлэг, өдрийн эмчилгээ, хэвтүүлэн эмчлэх эмийн эмчилгээ, эрчимт эмчилгээ болон шинээр нэвтрүүлэх тусламж үйлчилгээний өртгийг тооцоолон, төлбөр тариф, санхүүжилтийг нэмэгдүүлэх, талаар 6 удаа саналыг тус тус хүргүүлсэн. | 100 |

2024 онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөг дараах бодлогын баримт бичиг, тушаал шийдвэрийг үндэслэж боловсруулсан болно.Үүнд:

- “Алсын Хараа – 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого /МУУХХБ/
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ /ЗГҮАХ/
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 2022 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ /МУТЖҮЧ/
- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө
- Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд 2023 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээ /БДХСТ/
- СТ- Стратеги төлөвлөгөө
- ЭМС-ын 2023 оны 01 тоот албан даалгавруудаар тусгайлан нэмэлтээр үүрэг болгосон арга хэмжээнүүдийг тусгасан болно.

2024 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилгын хүрээнд нийт 43 ажил төлөвлөсөн. Үүнд:

- Шинээр төлөвлөсөн 10 ажил
- 2023 оноос хэрэгжүүлж ажиллаж байгаа 1 ажил
- Тогтмол зохион байгуулдаг 31 ажил